



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2020 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Биеийн тамир, спортын улсын хорооны үйл
ажиллагааны стратеги, зохион байгуулалтын
бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион
байгуулалтын бүтцийг батлах тухай


Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор, зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар тус тус баталсугай:

1. Бодлого, төлөвлөлтийн газар;
2. Төрийн захиргааны удирдлагын газар;
3. Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс;
4. Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс;
6. Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэс;
7. Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс;
8. Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ



Ерөнхий сайдын 2020 оны 39 дүгээр захирамжийн хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороо (цаашид “Улсын хороо” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-т “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратеги тодорхойлох, бодлогын удирдамж, удирдлага зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загварыг үндэслэн боловсруулав.

1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Биеийн тамир, спортын тухай хууль;
- Боловсролын тухай хууль
- Галт зэвсгийн тухай хууль;

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Үндэсний их баяр наадмын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн бус байгууллагын тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад засаглал болон өөрчлөлтийн удирдлага, байгууллагын өөрчлөлтийн онол, арга зүй, олон улсын болон өмнө хэрэгжсэн хөтөлбөрүүдийн туршлага, сургамжид үндэслэн хөтөлбөр боловсруулах ажилд оролцооны аргыг ашиглалаа. Мөн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал, тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.


1.5. Агентлагийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Агентлаг нь биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, эрхэлсэн сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Агентлаг нь өөрийн хариуцсан чиг үүргийн асуудлаар Засгийн газарт зөвлөхийн үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ. Хариуцсан чиг үүргийн дагуу иргэдэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь үйлчлүүлэгч буюу тус агентлагийн ажил, үйлчилгээг хэрэглэгчийн эрэлт, захиалга, даалгавар байхаар тооцов. Эдгээр үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдийн бүлгийг дор дурдсанаар тодорхойлов:

Төрийн захиргааны байгууллагын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Агентлагийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, иргэн байна. Агентлагийн стратегийн бодлого, зохицуулалт нь нэн түрүүнд үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж байгаа нийтлэг болон онцлог эрэлт, хэрэгцээг хангахад чиглэнэ.

Үндсэн үйлчлүүлэгч, хэрэглэгчийн үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тус тус тусган хэрэгжүүлнэ.

Хоёр. Агентлагийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарах биеийн тамир, спортын салбарын үндсэн зорилт, чиг үүрэг болох иргэд биеийн тамир, спортоор хичээллэх олон талт боломжийг бүрдүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, спортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний спортын өв соёлыг хамгаалж өвлүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр нөлөөг нэмэгдүүлж, спортын ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

2.2.1. биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

2.2.2. хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэний бие бялдрын түвшинг сайжруулах зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхийг насан туршийн боловсрол болгон хөгжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

2.2.3. спортын сургалт дасгалжуулалт, спортын анагаах ухааны үйл ажиллагаанд шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг сайжруулах;

2.2.4. биеийн тамир, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.2.5. биеийн тамир, спортын салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцыг төлөвлөх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг удирдах, зохицуулалтаар хангах, хэрэгжүүлэх;

2.2.6. биеийн тамир, спортын салбарын болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Агентлагийн эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Агентлаг нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, салбарын статистик мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийн нэгтгэх, нэгдсэн удирдлагаар хангах, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, спортын байгууллагуудын зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох нөхцөлийг бүрдүүлэх;

2.4.2. биеийн тамир, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх;

2.4.3. спортын сургалт дасгалжуулалт, спортын анагаах ухааны үйл ажиллагаанд шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, үндэсний спортын өв соёл, хэв маягийг хадгалж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг сайжруулах, тэмцээн, наадмын зохион байгуулалтыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;

2.4.4. хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэдийн бие бялдрын түвшинг сайжруулах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор насан туршийн боловсрол болгон хөгжүүлэх, биеийн тамирын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

2.4.5. биеийн тамир, спортын салбарын болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлэх;

2.4.6. байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4.7. биеийн тамир, спортын салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцыг төлөвлөх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, төсөв санхүүгийн гүйцэтгэлийг удирдах, зохицуулалтаар хангах, хэрэгжүүлэх;

2.4.8. үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын холбоодоор гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, олон улсын туршлага, арга технологийг нэвтрүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Стратегийн зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ.

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. биеийн тамир, спортын салбарын хөгжлийн дунд, урт хугацааны бодлогын чиг хандлагыг тодорхойлох, түүнд нийцсэн хөрөнгө оруулалт, төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, төсөл боловсруулах, батлуулах;

2.5.1.2. салбар хоорондын бодлогын уялдааг хангаж нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах;

2.5.1.3. биеийн тамир, спортын салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих дунд, урт хугацааны төсөл боловсруулах;

2.5.1.4. биеийн тамир, спортын талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, шаардагдах дүрэм, журам, баримт бичгийн төсөл боловсруулах;

2.5.1.5. биеийн тамир, спортын салбарын статистикийн мэдээллийг боловсруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

2.5.1.6. төрийн болон төрийн бус байгууллагын засаглалыг сайжруулахад болон аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чадавхыг дээшлүүлэх болон албан хаагчдын ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагааг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг зохион байгуулах, төрийн захиргааны удирдлагаар хангах;

2.5.2.2. салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, захиргааны хэм хэмжээг тогтоосон шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, зөрчлийг арилгах төсөл боловсруулах, хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх;

2.5.2.3. салбарын болон байгууллагын хүний нөөцийг спортын гадаад болон дотоодод урт, богино хугацааны сургалт, бакалавр, магистр, докторын сургалтад хамруулах, мэргэжилтэн солилцох, сэлгүүлэн ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. спортын сургалт дасгалжуулалтад шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандартыг боловсруулж, батлуулах, хяналт тавьж ажиллах;

2.5.3.2. үндэсний спортын өв соёл, хэв маягийг хадгалж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.3.3. тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, нийгэм-эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх;

2.5.3.4. улсын аварга шалгаруулах тэмцээн, наадам зохион байгуулах эрх, спортын цол зэрэг олгох, хяналт тавих үйл ажиллагаанд зохицуулалт хийх;

2.5.3.5. спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, чадавхыг сайжруулж, хамтын ажиллагааны хүрээг тэлэх;

2.5.3.6. спортын дасгалжуулагч, менежерийг мэргэшүүлэх, тамирчны өсөн дэвших чиглэлд үйл ажиллагааг зохион байгуулах.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортыг эрүүл аж төрөх арга хэрэглүүр болгон хэвшүүлэх ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.4.2. бие бялдрын түвшин тогтоох стандартыг боловсруулан бүх насны ангиллын нормативыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.4.3. биеийн тамир, спортын клубын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах, батламжлах, хяналт тавих;

2.5.4.4. салбарын биеийн тамирын арга зүйчдийг мэргэшүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах.

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх аргачлал боловсруулах, аргачлалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

2.5.5.2. салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;

2.5.5.3. агентлаг, харьяа байгууллага, спортын холбоодын үйл ажиллагаанд дотоод аудит хийх;

2.5.5.4. салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх;

2.5.5.5. хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх.

2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1. салбарын болон агентлагийн гадаад харилцааг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.5.6.2. салбарын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ажлыг зохион байгуулах;

2.5.6.3. биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, салбарын үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд холбох.

2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1. Төвлөрүүлэн захирагчийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.7.2. төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын саналыг хууль тогтоомжид заасан хугацаанд нэгтгэн боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

2.5.7.3. төсвийн төвлөрүүлэн захирагчийн бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, төрийн өмчийн бүртгэлд хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.7.4. төрийн сангийн төлбөр тооцоог хийх, нягтлан бодох бүртгэлийн бодлого, агентлагийн болон төсвийн шууд захирагчдийн санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, тасралтгүй явуулах, гүйцэтгэлийг тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх;

2.5.7.5. салбарын хөрөнгө оруулалт, жил бүрийн төсвийн төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах.

2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.5.8.1. үндэсний шигшээ багийн тогтолцооны дагуу тамирчдын залгамж халааг бэлтгэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.8.2. үндэсний шигшээ багийн ажил, үйлчилгээг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;

2.5.8.3. үндэсний шигшээ багт гадаадын мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчдыг гэрээгээр ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

2.5.8.4. спортын холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.5.8.5. эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр үндэсний шигшээ багийн спортын төрлийн холбоодтой гэрээ байгуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, дүгнэх, хяналт тавих;

2.5.8.6. дасгалжуулагчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа хариуцсан байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулах;

2.5.8.7. үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх;

2.5.8.8. үндэсний шигшээ багийн тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үзүүлсэн амжилт, статистик мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн сангийн өгөгдлийг бэлтгэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Агентлагийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааны стратегийн загвар

| Эрхэм зорилго | Үйл ажиллагааны стратегийн зорилт | Үйл ажиллагааны гол зорилт |
|--|--|---|
| <p>Төрийн захиргааны байгууллагын эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд оршино.</p> | <p>Салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, байгууллагуудын удирдлага зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох нөхцөлийг бүрдүүлэх</p> | <p>салбарын хөгжлийн дунд, урт хугацааны бодлого чиглэлийг тодорхойлох, түүнд нийцсэн хөрөнгө оруулалт, төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хуулийн төсөл, бодлого, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах</p> |
| | <p>Биеийн тамир, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх</p> | <p>төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чадавхыг дээшлүүлэх болон албан хаагчдын ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг зохион байгуулах</p> |
| | <p>Спортын сургалт дасгалжуулалтад шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, спортын холбоо, хувийн хэвшлийн оролцоог дэмжих</p> | <p>спортын сургалт дасгалжуулалтад шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, үндэсний спортын өв соёл, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, нийгэм-эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх</p> |
| | <p>Хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, бие бялдрын түвшинг сайжруулах идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхийг зорилгоор насан туршийн боловсрол болгон хөгжүүлэх, биеийн тамирын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</p> | <p>идэвхтэй хөдөлгөөн, спортыг иргэний эрүүл аж төрөх арга хэрэглүүр болгон хэвшүүлэх, биеийн тамирын ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах</p> |
| | <p>Салбарын болон агентлагийн үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тандалт, судалгаа хийх</p> | <p>байгууллагын удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааны чиглэлээр, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, тушаал шийдвэр, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хугацаат тайлангийн биелэлт, үр дүнд хяналт шинжилгээ хийх</p> |
| | <p>Байгууллагын гадаад хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах</p> | <p>салбарын болон байгууллагын гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн цахим сангаар дамжуулж, салбарын үйл ажиллагааг цахимжуулах</p> |
| | <p>Салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцыг төлөвлөх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, төсөв санхүүгийн гүйцэтгэлийг удирдах, зохицуулалтаар хангах</p> | <p>жил бүрийн төсвийн төслийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хийж салбарын төсвийн төслийг боловсруулах, хуваарилах, санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төсвийг шийдвэрлүүлэх</p> |
| | <p>Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын холбоодоор гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, олон улсын туршлага, арга технологийг нэвтрүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилын орчин нөхцөлийг бүрдүүлэх</p> | <p>үндэсний шигшээ багийн сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гэрээний дагуу зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналт тавих, дэмжлэг үзүүлэх</p> |

2.8. Агентлаг нь өөрийн эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөөг боловсруулан батлуулж ажиллана. Агентлагийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1. агентлагийн стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх (тухайн агентлагийн үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3. үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал агентлагийн бүтэц, нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. бүтцийн хувьд энгийн байх (газрын даргаас доод нэгжийг хүртэл хоёроос дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);


3.1.6. улс төржихгүй байх (тухайн агентлагийн төрийн захиргааны албан хаагч нь Ерөнхий сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид төвийг сахисан, өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх);

3.1.7. хангалттай чадавх, бодитой үйл ажиллагаатай байх (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон агентлагийн үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус агентлаг үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны дараахь загвартай байна.

Агентлагийн үйл ажиллагааны бүтцийн
ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

3.3.1. Бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд биеийн тамир, спортын салбарын хөгжлийн дунд, урт хугацааны бодлогын чиг хандлагыг тодорхойлох, түүнд нийцсэн хөрөнгө оруулалт, төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, төсөл боловсруулах, батлуулах, спортын салбар хоорондын бодлогын уялдааг хангаж нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, спортын салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөр боловсруулах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн хувилбар боловсруулах, салбар хоорондын бодлогын уялдааг хангах чиглэлээр яам, агентлаг, аймаг, нийслэл, сум дүүргийн захиргааны холбогдох байгууллага, судлаачидтай хамтран ажиллах, эрхэлсэн сайдын асуудлын хүрээнд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.2. Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын

соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, салбарын хүний нөөцийн үйл ажиллагааг зохицуулах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, чадавхыг дээшлүүлэх болон албан хаагчдын ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, тогтоол шийдвэрийн биелэлт гаргах, байгууллагын албан хэргийг хөтлөх, байгууллагын үйл ажиллагаанд удирдлагын үр нөлөөтэй арга барил, соёлыг нэвтрүүлэх, ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлэх, байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, удирдлагыг шуурхай мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.3. Спортын бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, спортын тэмцээн, наадмын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь спортын сургалт дасгалжуулалтад шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, сургалт-дасгалжуулалтын орчин, хэрэглэл материалын стандартыг боловсруулж батлуулах, мөрдүүлэх, дасгалжуулагч, тамирчны хөгжлийг дэмжих, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, спортын цол зэрэг олгох, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үндэсний спортын өв соёл, хэв маягийг хадгалж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, спортын төрийн бус байгууллагуудын чадавхыг сайжруулж, хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.4. Биеийн тамирын бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд биеийн тамирын бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн идэвхтэй аж төрөх орчинг бүрдүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, спортын клубын магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь идэвхтэй хөдөлгөөн, спортыг хүн амын эрүүл аж төрөх арга хэрэглүүр болгон хэвшүүлэх, биеийн тамирын ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, бие бялдрын түвшин тогтоох стандарт боловсруулах, спортын клубын магадлан итгэмжлэх, батламжлах, хяналт тавих, биеийн тамирын арга зүйчдийг мэргэшүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, гүйцэтгэлийн төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, салбарын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгааны хэлбэрээр хэрэгжүүлж салбарын бодлогыг үр дүнтэй болгох, салбарын болон байгууллагын үндсэн, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь салбарын бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах чиглэлээрх эрсдэлийг тодорхойлж, санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, салбарын өнөөгийн байдлыг үнэн зөв тогтоох, хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг оновчтой хийх, гүйцэтгэлийг тухай бүр шалгах, үр нөлөөг бодитоор үнэлж, дүгнэх, салбарын байгууллагууд, эрхэлсэн сайд, иргэдийн өмнө тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.6. Гадаад хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, олон улсын хурал, уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, байгууллагын гадаад харилцааны асуудлыг зохицуулах, олон улсын төсөл, хөтөлбөрийн бодлого, төсвийн хэрэгжилт, хяналт, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах, спортын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, иргэдэд мэдээллээр үйлчлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь салбарын гадаад хамтын ажиллагааны бодлого, зохицуулалтыг хангах, салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын хурал, уулзалт зохион байгуулах, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн зохицуулалт, уялдааг хангах, байгууллагын удирдлагад мэргэжлийн зөвлөгөө, шуурхай мэдээллээр хангах, салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, цахим үйлчилгээг боловсронгуй болгох, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.7. Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд спортын салбарын төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн төсвийн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах, салбарын харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, мэдээллээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь салбарын бодлого төлөвлөлт, хөтөлбөрийн дагуу санхүүжүүлэх, санхүүгийн (сангийн) тайлан, мэдээ гаргах, байгууллагын төсвийн үр ашгийг сайжруулах, байгууллагын удирдлагад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн богино хугацааны бодлого, төлөвлөлтийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавих, гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжих төслүүдийн зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, салбарын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн талаарх тооцоо судалгааг гаргах, ханган нийлүүлэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.8. Үндэсний шигшээ багийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд үндэсний шигшээ багийн спортын холбоодтой байгуулсан гэрээний хүрээнд хийх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох нөхцөлийг бүрдүүлэх, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, тамирчны спортын амжилтыг дээшлүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь үндэсний шигшээ багийн тогтолцооны дагуу тамирчдын залгамж халааг бэлтгэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, гадаадын өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчдыг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, статистик мэдээллийн сангийн өгөгдлийг боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.